

ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,

КАНАД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХООРОНДЫН

ГЭРЭЭ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, КАНАД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
(цаашид "Талууд" гэх)

Хууль ёсыг биелүүлэхэд хоёр талын хамтын ажиллагаа шаардлагатайг
чухалчлан,

Ялтныг харъяалах улсад нь ял эдлүүлэхийг зөвшөөрснөөр тэднийг
нийгэмших явдалд тус дэм үзүүлэхийг эрмэлзэн,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

Нэгдүгээр зүйл

Гэрээний хамрах хүрээ

1. Монгол Улсын хуулиар ял шийтгэл хүлээсэн Канад Улсын иргэн нь энэхүү
Гэрээнд заасан нөхцлийн дагуу Канад Улсын хорих байгууллагад буюу Канад
Улсын эрх бүхий байгууллагын хяналт дор ял шийтгэлээ үргэлжлүүлэн эдэлж
болно.

2. Канад Улсын хуулиар ял шийтгэл хүлээсэн Монгол Улсын иргэн нь энэхүү
гэрээнд заасан нөхцлийн дагуу Монгол Улсын хорих байгууллагад буюу
Монгол Улсын эрх бүхий байгууллагын хяналт дор ял шийтгэлээ
үргэлжлүүлэн эдэлж болно.

Хоёрдугаар зүйл

Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү гэрээний зорилгын дагуу:

(a) "Ял ногдуулсан Тал" гэж ялтныг шилжүүлэн өгч байгаа Талыг ойлгоно;

(b) "Хүлээн авагч Тал" гэж ялтныг шилжүүлэн авч байгаа Талыг ойлгоно;

(c) "Ялтан" гэж хэлэлцэн тохирогч аль нэг талын нутаг дэвсгэр дээр ял
шийтгэл хүлээсэн, ял шийтгэл эдлэж байгаа, тодорхой нөхцөлтэйгээр
суллагдсан, мөн олон нийтийн хараа хяналтад бусад хэлбэрээр байгаа
этгээдийг ойлгоно;

(d) "Өршеөл" гэж ногдуулсан ял шийтгэлийг хэрэгсэхгүй болгож байгаа буюу ял эдлэх хугацааг хөнгөрүүлж өөрчилж байгаа энэрэнгүй үйлдлийг ойлгоно.

Гуравдугаар зүйл

Шилжүүлэх нөхцөл

Энэхүү гэрээг дараахь нөхцөлд хэрэглэнэ:

(a) Тухайн Ялтны ял шийтгэл хүлээсэн үйлдэл нь Хүлээн авагч Талын хуулиар гэмт хэрэгт тооцогдож, ял шийтгэл ногдуулж болохоор байна. Энэ утгаараа тухайн гэмт үйлдлийн үндсэн шинжид үл хамаарах нөхцөл байдал нь уг гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцож ял шийтгэл ногдуулахад нөлөөлөхгүй;

(b) Шилжүүлэн өгч байгаа ялтан нь Хүлээн авагч Талын иргэн байх;

(c) Шилжүүлэн өгөх ялтан нь цэргийн гэмт хэрэгт шийтгэгдээгүй байх;

(d) Шилжүүлэн авах тухай хүсэлт гаргах үед тухайн ялтны ял шийтгэл эдлэх үлдсэн хугацаа нь 6 сараас доошгүй байх;

(e) Ялтны гэм буруу болон ял шийтгэлтэй нь холбоотойгоор давж заалдах болон хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаагүй, эсвэл ял шийтгэл ногдуулж байгаа Талд ял шийтгэлээ хүлээж байгаа буюу тухайн асуудлыг хеен хэлэлцэх буюу давж заалдах гомдол гаргах хугацаа дууссан байх;

(f) Тухайн ялтан өөрийг нь шилжүүлэхийг зөвшөөрсөн байх;

(g) Ял ногдуулсан болон Хүлээн авагч Талууд ялтныг шилжүүлэхийг харилцан зөвшөөрсөн байх.

Дөрөвдүгээр зүйл

Бүрэн эрх

Талууд энэхүү Гэрээний заалтыг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий байгууллагыг томилно.

Тавдугаар зүйл

Мэдээлэл өгөх үүрэг

Ял ногдуулсан Тал нь энэхүү гэрээнд хамаарах ялтанд уг Гэрээний гол агуулгыг тайлбарлаж өгнө.

Зургадугаар зүйл

Хүсэлт тавих ба хүсэлтэд хариу өгөх

1. Ялтан нь Ял ногдуулсан Тал болон Хүлээн авагч Талд шилжүүлэх тухай өөрийн хүсэл сонирхлоо илэрхийлж болно.

2. Ялтныг шилжүүлэх тухай хүсэлтийг ял ногдуулсан Тал болон Хүлээн авагч Талын аль аль нь гаргаж болно. Шилжүүлэх хүсэлтийг хүсэлт гаргаж байгаа Талын эрх бүхий байгууллагаас Хүсэлт Хүлээн авч байгаа Талын эрх бүхий байгууллагад хандаж гаргана. Хариуг мэдээлэл авсан сувгаар даруй мэдэгдэнэ.

3. Хүсэлт болон түүнд өгөх хариуг бичгээр үйлдэнэ.

4. Хүлээн авагч Тал болон ял ногдуулсан Тал нь ялтанг шилжүүлэхийг хүлээн зөвшөөрөх, эсвэл татгалзах бүрэн эрхтэй байна.

5. Талууд шийдвэр гаргахдаа тухайн ялтны нийгэмшихэд тус нэмэр болох бүхий л хүчин зүйлийг харгалзан үзнэ.

6. Талууд ялтны хүсэлтийн дагуу гаргасан аливаа шийдвэр, арга хэмжээнийхээ талаар ялтанд бичгээр мэдээлнэ.

Долдугаар зүйл

Зөвшөөрөл ба түүний нотолгоо

Ял ногдуулсан Тал ялтнаас шилжүүлэн өгөх тухай зөвшөөрлийг сайн дурын, хууль зүйн үр дагаврын талаар бүрэн ойлголттой байсны үндсэн дээр авсан болохыг ялтныг шилжүүлэхээс өмнө тухайн улсын эрх бүхий албан тушаалтнаар дамжуулан нотлох боломжийг Хүлээн авагч Талд олгоно.

Наймдугаар зүйл

Мэдээллээр хангах үүрэг

1. Ял ногдуулсан Улс нь ялтанд ял шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийн баталгаажсан хуулбар, ял шийтгэл оногдуулах үндэслэл болсон баримт нотолгоо, ял шийтгэлийн төрөл, түүний эхэлсэн болон үргэлжлэх хугацаа, мөн ял эдэлсэн болон урьдчилан хоригдсон хугацаа, ял шийтгэлээс хассан хугацааны талаархи мэдээллийг Хүлээн авагч Талд өгнө.

2. Ял ногдуулсан Тал нь ялтны эрүүл мэнд болон нийгэмшлийн тухай мэдээ тайлан, эмчлүүлж байсан, түүнчлэн цаашид авах эмчилгээний талаарх мэдээллийг тохиромжтой үед Хүлээн авагч Талд өгнө.

3. Хүлээн авагч Тал нь энэхүү Гэрээний зээлтийг хэрэгжүүлэх үүднээс шилжүүлэн авах ялтантай холбоотой бусад мэдээллийг хүссэн хүсэлтийг гаргаж болно.

4. Дээр дурдсан мэдээлэл нь Хүлээн авагч Талын албан ёсны аль нэг хэл дээр орчуулагдаж, зохих ёсоор баталгаажсан байна.

Есдүгээр зүйл

Шилжүүлэх журам

1. Ялтныг шилжүүлэх ажиллагааг Талуудын тохиролцсон газар гүйцэтгэнэ.

2. Хүлээн авагч Тал нь ялтныг дамжин өнгөрүүлэх болон ял шийтгэл эдлүүлэх газар буюу хорих байгууллагад хүргэх хүртэлх тээвэрлэлтийг хариуцна.

3. Хүлээн авагч Тал нь ялтныг дамжин өнгөрүүлэх шилжсэн үеэс ял шийтгэл эдэлж дуусах хүртэлх хугацааны зардлыг хариуцна.

Аравдугаар зүйл

Ял шийтгэлийг эдлүүлэх журам

1. Хүлээн авагч Тал нь Ял ногдуулсан Талаас тогтоосон ял шийтгэлийн төрөл, хэлбэр, үргэлжлэх хугацааг дагаж мөрдөнө.

2. Хэрэв ногдуулсан ял шийтгэл нь Хүлээн авагч Талын хууль тогтоомжид нийцэхгүй бол Хүлээн авагч Тал нь тухайн гэмт хэрэгт ногдуулах ялыг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу өөрчилж болно. Уг ял шийтгэлийн төрөл, хэлбэр, хугацаа нь Ял ногдуулсан Талаас ногдуулсан ял шийтгэлээс хүнд байж болохгүй бөгөөд Хүлээн авагч Талын хуульд заасан ялын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

3. Энэ Гэрээнд өөрөөр заагаагүй бол ялтанд ял шийтгэл эдлүүлэх ажиллагаа нь Хүлээн авагч Талын хууль тогтоомж, бусад дүрэм, журмын дагуу явагдана. Гэхдээ Ял ногдуулсан Тал ялтанд уучлал, ершөөл үзүүлэх эрхтэй бөгөөд Хүлээн авагч Тал энэ тухай мэдэгдлийг хүлээн авч зохих арга хэмжээ авна.

4. Хүлээн авагч Тал нь Ял ногдуулсан Талаас бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу ял шийтгэл эдлүүлэх ажиллагаатай холбоотой мэдээллээр хангана.

5. Энэхүү Гэрээний дагуу шилжүүлэн өгч байгаа ялтанд түүний ял шийтгүүлсэн гэмт хэргийн төлөө Хүлээн авагч Талын хуулиар дахин хорьж саатуулан ял шийтгэл ногдуулж болохгүй.

Арваннэгдүгээр зүйл

Насанд хүрээгүй ялтан

Энэхүү Гэрээг аль нэг Талын хууль тогтоомжийн дагуу хараа хяналтад байгаа болон бусад төрлийн арга хэмжээ авагдсан насанд хүрээгүй ялтанд хамааруулан хэрэглэж болно. Талууд өөрийн хууль тогтоомжийн дагуу шилжүүлэх тухайн этгээдэд тохирох арга хэмжээг тохиролцон шийдвэрлэнэ. Шилжүүлэх зөвшөөрлийг насанд хүрээгүй этгээдийн хууль ёсны төлөөлөгчөөс авна.

Арванхоёрдугаар зүйл

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх

Талууд энэхүү Гэрээг хэрэгжүүлэх зорилгоор өөрсдийн нутаг дэвсгэр дээр шаардлагатай захиргааны арга хэмжээ авах эрхтэй бөгөөд үүний үр дүнд Талуудын нутаг дэвсгэр дээр ногдуулсан ял шийтгэлийг эдлүүлэх бүрэн боломж бүрдэнэ.

Арвангуравдугаар зүйл

Төгсгөлийн заалтууд

1. Энэхүү Гэрээг соёрхон батлах бөгөөд Талууд соёрхон баталсан батламж жуух бичгийг солилцсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Гэрээ нь 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд хэрэв Талуудын аль нэг нь Гэрээг дуусгавар болгох тухай хүсэлтийг Гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа дуусахаас зургаагаас доошгүй сарын өмнө нөгөө Талдаа бичгээр мэдэгдээгүй бол Гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа дахин гурав, гурван жилээр сунгагдах болно.


ДЭЭР ДУРДСАНЫГ НОТОЛЖ: Талуудын Засгийн газраас бүрэн эрх олгосны дагуу энэхүү Гэрээнд гарын үсэг зурав.

Энэхүү Гэрээг 2004 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Оттава хотноо англи, франц, монгол хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

— МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



КАНАД УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



TREATY
BETWEEN
THE GOVERNMENT OF MONGOLIA
AND
THE GOVERNMENT OF CANADA
ON
THE TRANSFER OF OFFENDERS

THE GOVERNMENT OF MONGOLIA AND THE GOVERNMENT OF CANADA, hereinafter referred to as the "Parties";

AGREEING on the necessity of mutual cooperation in the administration of justice, and

DESIRING to facilitate the social reintegration of offenders by allowing them to serve their sentences in the country of which they are citizens,

HAVE AGREED to the following:

ARTICLE I

Scope of Application

1. Sentences imposed in Mongolia on Canadian citizens may be served in Canada in penal institutions or under the supervision of Canadian authorities in accordance with the provisions of this Treaty.
2. Sentences imposed in Canada on Mongolian citizens may be served in Mongolia in penal institutions or under the supervision of Mongolian authorities in accordance with the provisions of this Treaty.

ARTICLE II

Definitions

For the purposes of this Treaty:

- (a) "Sentencing State" means the Party from which the offender is to be transferred;
- (b) "Receiving State" means the Party to which the offender is to be transferred;
- (c) "Offender" means a person who, in the territory of either Party, has been sentenced and is serving a term of imprisonment, a term of conditional release, or any other form of community supervision; and

- (d) "Pardon" means an act of clemency which cancels the conviction or alters the duration of the sentence.

ARTICLE III

Conditions for Transfer

This Treaty shall apply under the following conditions:

- (a) That the conduct for which the offender was sentenced is one which is punishable as a crime in the Receiving State. For this purpose, no account shall be taken of differences that have no bearing on the nature of the offence;
- (b) That the offender is a citizen of the Receiving State;
- (c) That the offender has not been convicted of an offence that is solely an offence under military law;
- (d) That at least six months of the offender's sentence remain to be served at the time of the application;
- (e) That no proceedings by way of appeal or by extraordinary review procedure upon the offender's conviction or sentence is pending in the Sentencing State and that the prescribed time or appeal has expired;
- (f) That the offender has consented to the transfer; and
- (g) That the Sentencing and Receiving State agree to the transfer.

ARTICLE IV

Authority

Each Party shall designate an authority to carry out the provisions of this Treaty.

ARTICLE V

Obligation to Inform

An offender to whom the present Treaty may apply shall be informed by the Sentencing State of the substance of the Treaty.

ARTICLE VI

Requests and Replies

1. The offender may express his or her interest for transfer to the Sentencing State or to the Receiving State.
2. The request for transfer may be made by the Sentencing State or the Receiving State. The request shall be addressed to the authority of the

requested State by the authority of the requesting State. Replies shall be communicated through the same channels without delay.

3. Requests and replies shall be made in writing.
4. The Receiving State and the Sentencing State shall retain absolute discretion to approve or refuse the transfer.
5. In making their decision, each Party shall consider all factors that may contribute to the offender's social reintegration.
6. An offender shall be informed, in writing, of any action and decision taken by either State on the request.

ARTICLE VII

Consent and its Verification

Before the transfer, the Sentencing State shall afford an opportunity to the Receiving State, if it so desires, to verify through an officer designated by the Receiving State, that the offender's consent to the transfer has been given voluntarily and with full knowledge of the legal consequence thereof.

ARTICLE VIII

Obligation to furnish information

1. The Sentencing State shall furnish to the Receiving State a certified copy of the judgment convicting the offender, a statement of facts upon which the sentence was based, information on the nature, duration and date of commencement of the sentence and a statement indicating how much of the sentence has already been served, including any pre-trial detention and remission of sentence.
2. The Sentencing State shall provide, whenever appropriate, any medical or social reports on the offender, information about his or her treatment in the Sentencing State and any recommendations for further treatment.
3. The Receiving State may request any additional information regarding the offender to enable it to carry out the provisions of this Treaty.
4. The above information shall be translated into an official language of the Receiving State and duly authenticated.

ARTICLE IX

Procedure for Transfer

1. The transfer of the offender shall occur at a place agreed to by both Parties.
2. The Receiving State shall be responsible for the custody and transport of the offender to the prison, penitentiary, or place where the sentence shall be completed.

3. The Receiving State shall be responsible for expenses incurred by it in the transfer of the offender from the time when the offender passes into its custody until the completion of the sentence.

ARTICLE X

Procedures for Execution of Sentences

1. The Receiving State shall be bound by legal nature and duration of the sentence as determined by the Sentencing State.
2. If, however, the sentence is incompatible with the laws of the Receiving State, that State shall adapt the sentence to one which is prescribed by its own law for a similar offence. This shall not aggravate, by its nature or duration, the sanctions imposed in the Sentencing State or exceed the prescribed maximum in the Receiving State.
3. Except as otherwise provided in this Treaty, the completion of the transferred offender's sentence shall be in accordance with the laws and procedures of the Receiving State. However, the Sentencing State shall retain the right to pardon or grant amnesty to the offender, and the Receiving State shall take appropriate action upon receiving notification of such pardon or amnesty.
4. On receipt of a written request from the Sentencing State, the Receiving State shall provide information regarding the administration of the sentence.
5. An offender transferred under this Treaty may not again be detained, tried or sentenced in the Receiving State for the same offence upon which the sentence to be executed is based.

ARTICLE XI

Young Offenders

This Treaty may be extended to persons subject to supervision or other measures under the laws of one of the Parties relating to youthful offenders. The Parties shall, in accordance with their laws, agree on the type of treatment to be accorded to such individuals upon transfer. Consent for the transfer shall be obtained from the person legally authorized to consent on behalf of the young person.

ARTICLE XII

Implementing Legislation

In order to carry out the purposes of this Treaty, each Party shall take whatever legislative measures that are necessary and shall establish adequate administrative procedures so that the sentences imposed shall have legal effect within their respective territories.


ARTICLE XIII

Final Provisions


1. This Treaty shall be subject to ratification and shall enter into force on the date on which the instruments of ratification are exchanged.
2. The present Treaty shall remain in force for three years and shall be automatically renewed for additional periods of three years unless one of the Parties gives written notice to the other of its intention to terminate the Treaty at least six months prior to the expiration of any three-year period.

IN WITNESS WHEREOF the undersigned, being duly authorized thereto by their respective Governments, have signed the present Treaty.

DONE, in duplicate, in Ottawa, this 20th day of October 2004, in the English, French and Mongolian languages, each version being equally authentic.



FOR THE GOVERNMENT
OF MONGOLIA



FOR THE GOVERNMENT
OF CANADA